

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ардчилсан намын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Цахим хаяг: info@mindug.mn Улаанбаатар хот. 2025 он	Миндүг аудит ХХК-ийн	
	Гүйцэтгэх захирал:	С.Энхтөр
	Утас: 95957791	Цахим хаяг: Director@mindug.mn
	Аудитын менежер:	Г.Уранбилэг
	Утас: 90890033	Цахим хаяг: info@mindug.mn
	Аудитор:	Б.Бүзмаа, Л.Оюунбилэг
		Цахим хаяг: buzmaa@mindug.mn
		Т.Цагаанбаяр, Н.Ичинхорлоо
		Ж.Мөнхшүр, Д.Сарнай
		Л.Золбоо, Ц.Номингоо
		Цахим хаяг: info@mindug.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	4
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	8
4. АУДИТЫН ТАЙЛАН	20
4.1 Ерөнхий зүйл	20
4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ..	20
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	20
4.5.1 Завсрын аудитын талаар.....	20
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	21
5.1 Зөвлөмж	21
5.4 Зөвлөмж	21
5.5 Зөвлөмж	22
5.6 Зөвлөмж	22
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	22

Товчилсон үгийн жагсаалт

НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СЕХ	Сонгуулийн Ерөнхий Хороо



ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ

2025 оны 03 сарын 14 өдөр

Дугаар 25-Т/03

Улаанбаатар хот

“АРДЧИЛСАН НАМ”-ЫН УДИРДЛАГАД

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Санхүүгийн тайлангийн аудит хийсэн тухай тайлан

Дүгнэлт

Бид “АРДЧИЛСАН НАМ”-ын /цаашид нам гэх/ 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн байдлын тайлан, дэлгэрэнгүй орлого, үр дүнгийн тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, санхүүгийн тайлангийн тодруулга болон нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй, бусад тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр, “АРДЧИЛСАН НАМ”-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн тайлан нь Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартад нийцүүлэн гаргасан Сангийн сайдын заавар, журмын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-ын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Эдгээр стандартын дагуу бид хүлээх үүрэг хариуцлагаа энэхүү аудитын тайлангийн Аудиторын үүрэг хариуцлага хэсэгт багтаан харуулсан. Бидний хувьд, санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн стандартын шаардлагуудын дагуу тус Намаас хараат бус бөгөөд бид эдгээр шаардлагын ёс зүйтэй холбоотой бусад үүрэг хариуцлагаа биелүүлсэн болно. Бидний олж авсан нотлох зүйл нь бидний дүгнэлтэд зохистой үндэслэл болж чадна гэдэгт итгэлтэй байна.

Тасралтгүй үйл ажиллагааны зарчимтай холбоотой асуудлууд

Тасралтгүй үйл ажиллагаатай холбоотой материаллаг тодорхой бус байдал үүссэн тохиолдол бидэнд ажиглагдаагүй болно. Цаашид үйл ажиллагаагаа хэвийн явуулна гэсэн төсөөллөөр тайлангаа бэлтгэсэн байна.

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4-р хороо,
Хиймөр хотхон, 4-7 байр, 7-1 тоот
Утас: 91160110, 95957791
И-Мэйл: info@mindug.mn, director@mindug.mn



Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн үнэлэмжээр, тайлант жилийн санхүүгийн тайланд хийсэн аудитад хамгийн ихээр нөлөө үзүүлэхүйц асуудлууд нь аудитын гол асуудлууд болдог. Эдгээр асуудлууд нь санхүүгийн тайланг бүхэлд нь хамарсан, аудитын ажлын агуулга болон дүгнэлтийн хэлбэрт тусгалаа олсон бөгөөд эдгээр асуудал дээр бид тусад нь санал дүгнэлт гаргаагүй болно.

Бусад мэдээлэл

Бусад мэдээлийн хувьд удирдлага хариуцах бөгөөд жилийн санхүүгийн тайланд орсон боловч бидний гаргасан аудиторын тайланд ордоггүй. Бид бусад мэдээллийн талаар аливаа баталгаажилт гаргадаггүй.

Санхүүгийн тайланд засаглах удирдлага болон удирдлагын хүлээх үүрэг хариуцлага

Санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу гаргаж, үнэн зөв толилуулах нь бидний үүрэг хариуцлага бөгөөд энэхүү үүрэг, хариуцлагад аливаа алдаа, залилангийн улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайланг бэлтгэх, толилуулахтай холбоотой дотоод хяналтын тогтолцоог бий болгож, хэрэгжүүлэх үүрэг хариуцлагууд багтана.

Ийнхүү санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлага нь намын тасралтгүй үргэлжлэх чадварыг үнэлэх, тодруулга гаргах, намаа татан буулгах эсвэл үйл ажиллагааг нь зогсоох, өөр бусад арга хэмжээ авах зорилгогүй байгаа тохиолдолд нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй үйл ажиллагааны зарчмын үндэслэлийг ашиглах болон тухайн зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулга хэлбэрээр бэлтгэх зэрэг үүрэг хүлээнэ.

Засаглах удирдлага нь намын санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг хариуцлага

Бидний үүрэг, хариуцлага бид хийж гүйцэтгэсэн аудитаа үндэслэн эдгээр санхүүгийн тайлангуудын талаар хараат бус дүгнэлт өгөх явдал юм. АОУС-аар санхүүгийн тайлангууд нь материаллаг зөрчилтэй илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй магадлагаа олж авахын тулд аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг биднээс шаарддаг.

Аудитын ажилд санхүүгийн тайлангийн дүн болон санхүүгийн тайлангийн тодруулгыг нотлох зүйл олж авах горимуудыг гүйцэтгэх ажил болно. Аудитын явцад тус намд хэрэглэгдэж байгаа нягтлан бодох бүртгэлийн зарчмууд, удирдлагын хийсэн нягтлан бодох бүртгэлтэй холбоотой тооцоолол, санхүүгийн тайлангуудын бодитой эсэхэд үнэлэлт өгөв. Мөн бид мэргэжлийн үл итгэх байдлыг баримтлан ажилласан. Үүнд:

- Залилан эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдлийг тодорхойлж, түүнийг үнэлэн уг эрсдэлд тохирохуйц аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж өөрсдийн дүгнэлтийнхээ үндэслэл болохуйц хангалттай, тохиромжтой аудитын баримт нотолгоог олж авна.
- Залилангаас үүссэн материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүссэн буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдлээс харьцангуй их

байдаг, учир нь залиланд хуйвалдаан, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу илэрхийлэх болон дотоод хяналтыг орхигдуулах зэрэг орно.

- Намын дотоод хяналтын үр ашигтай байдалд тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитын ажилтай холбоотой дотоод хяналтын талаарх ойлголт олж авдаг.
- Намын ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, удирдлагын хийсэн тооцоолол, тодруулгын зохистой байдлыг үнэлсэн.
- Намын тасралтгүй байх зарчимд материаллаг тодорхойгүй байдалд эргэлзээ үүссэн бол тодруулгын хэсэгт анхаарлаа хандуулж, тодруулгад хангалттай дурдаагүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудитын тайлан гарах өдөр хүртэл олж авсан баримт нотолгоондоо үндэслэн дүгнэлтээ гаргасан.
- Тодруулгыг багтаагаад санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлж, санхүүгийн тайланд үнэн зөв толилуулгын шаардлагыг хангахуйц байдлаар гол гол ажил гүйлгээ, үйл явдлуудыг илэрхийлсэн эсэхийг тодорхойлсон.

Энэхүү тайлан нь Монгол улсын “Улс төрийн намын тухай” хууль /шинэчилсэн найруулга/-ын 38 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан Сонгуулийн төв байгууллага болон тус улс төрийн намын удирдлагад зориулагдсан ба аливаа өөр зорилго агуулаагүй болно. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд бусад этгээдийн өмнө хариуцлага хүлээхгүй болно.

Бид энэхүү Аудитын ажлыг хийж гүйцэтгэж, аудитын тайланг бэлтгэсэн болно.



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Санхүүгийн байдлын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	644,275,954.40	102,574,818.39
Авлага	12,990,164.00	25,090,164.00
Бараа материал	378,830,985.00	375,265,257.00
Бусад эргэлтийн хөрөнгө	-	5,365,955.81
Эргэлтийн хөрөнгийн дүн	1,036,097,103.40	508,296,195.20
Үндсэн хөрөнгө	333,190,394.54	514,937,848.21
Биет бус хөрөнгө	5,932,750.35	11,205,796.35
Бусад эргэлтийн бус хөрөнгө	14,574,793.00	14,574,793.00
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	353,697,937.89	540,718,437.56
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,389,795,041.29	1,049,014,632.76
Татвар,НДШ-ийн өр төлбөр	53,315,406.85	438,329,991.77
Богино хугацаат өр төлбөр	5,120,894.92	32,912,513.26
Богино хугацаат өр төлбөрийн дүн	58,436,301.77	471,242,505.03
Бусад урт хугацаат өр төлбөр	667,106,480.96	30,606,480.96
Урт хугацаат өр төлбөрийн дүн	667,106,480.96	30,606,480.96
НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	725,542,782.73	501,848,985.99
Өмч	1,202,317,952.63	1,202,317,952.63
Хуримтлагдсан үр дүн	-538,065,694.07	-655,152,305.86
НИЙТ ӨМЧИЙН ДҮН	664,252,258.56	547,165,646.77
ӨР ТӨЛБӨР БА ӨМЧИЙН ДҮН	1,389,795,041.29	1,049,014,632.76

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Орлого, зардлын зүйл	Өмнөх үеийн дүн	Тайлант үеийн дүн
Намын гишүүний татвар	2,822,791,000.00	1,890,525,559.00
Сонгуульт гишүүний татвар	-	3,565,000,000.00
Мөнгөн хандив	444,971,800.00	207,762,000.00
Төрийн санхүүжилт	137,500,000.00	442,964,844.00
Төслийн санжүүжилт	368,000,000.00	-
Намын өөрийн орлого	421,186,782.33	44,680,696.16
Үйл ажиллагааны орлогын нийт дүн	4,194,449,582.33	6,150,933,099.16
Ажиллагсдын зардал	738,052,367.88	1,262,499,576.90
Үйл ажиллагааны урсгал зардал	2,509,638,998.94	4,432,062,533.05
Нийгмийн бүлгүүдийн улс төрийн оролцоог дэмжих сургалтын зардал	-	100,017,699.00
Намын гишүүдийн болон иргэдийн боловсролыг дээшлүүлэх сургалтын зардал	-	85,572,500.00
Судалгаа хийх, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх зардал	-	212,547,200.00
Сонгуулийн зардал	-	94,367,500.00
Бусад үйл ажиллагааны зардал	393,575,700.17	80,952,702.00
Үйл ажиллагааны зардлын нийт дүн	3,641,267,066.99	6,268,019,710.95
Үйл ажиллагааны үр дүн (1-2)	553,182,515.34	-117,086,611.79
Татварын өмнөх ашиг, алдагдал (3+3.1-3.2)	553,182,515.34	-117,086,611.79
Орлогын татварын зардал	125,130.85	-
Татварын дараах ашиг, алдагдал (4-5)	553,057,384.49	-117,086,611.79
Тайлант үеийн ашиг, алдагдал (6-7)	553,057,384.49	-117,086,611.79
Тайлант хугацааны нийт дэлгэрэнгүй орлогын дүн (8+9)	553,057,384.49	-117,086,611.79

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Үзүүлэлт	Өмнөх үеийн дүн	Тайлант үеийн дүн
Намын гишүүний татвар	3,072,929,700.00	1,890,525,559.00
Сонгуульт гишүүний татвар	5,000,000.00	3,565,000,000.00
Иргэний өгсөн мөнгөн хандив	811,438,900.00	195,766,000.00
Хуулийн этгээдийн өгсөн мөнгөн хандив	-	11,996,000.00
Төрийн санхүүжилт	137,500,000.00	442,964,844.00
Өөрийн хөрөнгийг захиран зарцуулах замаар олсон орлого	208,547,082.33	44,347,000.00
Бусад	55,500,000.00	-
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	4,290,915,682.33	6,150,599,403.00
Ажиллагсдад төлсөн мөнгө	883,817,267.10	1,075,036,806.64
Ашиглалтын зардалд төлсөн	175,692,164.31	769,520,163.97
Төрийн санхүүжилтийн зардал	-	295,762,772.00
Хангамжийн зүйл худалдан авахад төлсөн	41,743,150.00	590,891,868.90
Бэлтгэн нийлүүлэгчдэд төлсөн мөнгө	293,771,643.00	1,180,376,115.20
Бусад	2,725,646,579.64	2,203,143,390.46
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн зарлага	4,120,670,804.05	6,114,731,117.17
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	170,244,878.28	35,868,285.83
Үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	188,909,500.00
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн зарлага	-	188,909,500.00
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн/2.4-2.8/	-	-188,909,500.00
Холбоотой талд өгөх өглөг	-	14,066,083,919.51
Хүүний орлого	-	333,696.16
Бусад	-	20,000,000.00
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн орлого	-	14,086,417,615.67
Холбоотой талд өгөх өглөг	-	14,475,077,537.51
Бусад	60,000,000.00	-
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн зарлага	60,000,000.00	14,475,077,537.51
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн/3.4-3.7	-60,000,000.00	-388,659,921.84
Нийт цэвэр мөнгөн гүйлгээ/1.18+2.9+3.8+4/	110,244,878.28	-541,701,136.01
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	534,031,076.12	644,275,954.40
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	644,275,954.40	102,574,818.39

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Өмчийн зүйл	Өмч	Хуримтлагдсан үр дүн	Нийт дүн
2023 оны 12 -р сарын 31-ны өдрийн үлдэгдэл	1,202,317,952.63	-1,091,123,078.56	111,194,874.07
Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал		553,057,384.49	553,057,384.49
2023 оны 12 -р сарын 31-ны өдрийн үлдэгдэл	1,202,317,952.63	-538,065,694.07	664,252,258.56
Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал		-117,086,611.79	-117,086,611.79
2024 оны 12-р сарын 31-ны өдрийн үлдэгдэл	1,202,317,952.63	-655,152,305.86	547,165,646.77

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

АУДИТ ХИЙСЭН ҮНДЭСЛЭЛ, ЗОРИЛГО, ХҮРЭХ ҮРДҮН,

ЦАР ХҮРЭЭ, ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг. Үндэслэл

Улс төрийн намын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2-д “Сонгуулийн төв байгууллага энэ хуулийн 38 дугаар зүйлд заасны дагуу намын санхүүгийн тайланд аудитын хуулийн этгээдээр хараат бусаар дүгнэлт гаргуулах ажлыг зохион байгуулж, хяналт тавина” гэж заасан.

Хоёр. Зорилго

“Миндүг Аудит” ХХК нь Намын санхүүгийн тайланг нягтлан бодох бүртгэл, бусад баримт бичиг болон намын гүйцэтгэх төв байгууллагаас өгсөн тайлбар, тодруулгыг үндэслэн холбогдох Аудитын Олон Улсын Стандартын дагуу шалгаж, баталгаажуулан дүгнэлт тайлан гаргана.

Гурав. Хүрэх үр дүн

Улс төрийн намын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1.-д “Нам жилийн эцсийн санхүүгийн тайлангаа жил бүрийн 03 дугаар сарын 15-ны өдрийн дотор Аудитын тухай хуульд заасан шаардлагыг хангасан хуулийн этгээдээр дүгнэлт гаргуулан аудит хийсэн санхүүгийн тайланг Сонгуулийн төв байгууллагад хүргүүлнэ” гэж заасны дагуу намуудын санхүүгийн тайланд аудит хийж хуульд заасан хугацаанд сонгуулийн төв байгууллагад хүргүүлсэн байх ба Улс төрийн намын тухай хуулийн хэрэгжилт хангагдана.

Дөрөв. Аудитын ажлын цар хүрээ

Бид аудитын явцад Аудитын Олон Улсын Стандарт, Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт болон тэдгээрт нийцүүлэн эрх бүхий байгууллагаас гаргасан нягтлан бодох бүртгэлийн холбогдох стандарт, заавар журам, аргазүй, мөн Аудитын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.3, Улс төрийн намын тухай хууль, Улс төрийн намын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль, Улс төрийн намын санхүүгийн тайлангийн бүтэц, тайлагнах журам, Намд төрийн санхүүжилт олгох, шууд бус дэмжлэгийг шийдвэрлэх, намын санхүү болон үйл ажиллагааг тайлагнах, мэдээлэх, хяналт тавих журам, Төрийн аудитын тухай хууль, Монгол Улсын Их хурлын сонгуулийн тухай хууль, Аймаг, сум, нийслэл дүүргийн сонгуулийн тухай хууль болон бусад холбогдох хууль, тогтоомж, дүрэм, журамд нийцүүлэн үнэн зөв гаргасан эсэх талаар аудит хийж, дүгнэлт гарган баталгаажуулсан.

АЖЛЫН ДААЛГАВАР, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЦАР ХҮРЭЭ, ТАЙЛАН

3.1 Намын санхүүгийн тайлангийн аудитыг гүйцэтгэсэн, хянаж баталгаажуулсан

Санхүүгийн тайлангийн аудитыг 2025 оны 2 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн 2025 оны 3 дугаар сарын 25-ны өдрийг хүртэл “Миндүг аудит” ХХК-ийн аудитын менежер Г.Уранбилэг, аудитор Б.Бүзмаа, Л.Оюунбилэг, хуульч Л.Золбоо, Ц.Номингоо, туслах аудитор Д.Сарнай Н.Ичинхорлоо, Т.Цагаанбаяр, Ж.Мөнхшүр нар хийж гүйцэтгэж, гүйцэтгэх захирал С.Энхтөр хяналт тавьж ажиллалаа.

3.2 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Ардчилсан Нам нь Хүн төрөлхтний нийтлэг хөгжлийн чиг хандлагыг эрхэмлэн Ардчилсан Үндсэн хуулийн суурь зарчмуудыг хамгаалж, ардчилсан хувьсгалын ололт амжилт, Монгол улсын нийгэм, улс төр, эдийн засгийн хөгжилд нэвтрүүлсэн дэвшилтэт санаачилга, өөрчлөлт шинэчлэлт, бүтээн байгуулалтаараа бахархаж, цаашдын бодлого, үйл ажиллагаандаа хувь хүний эрх чөлөө, эдийн засгийн эрх чөлөө, улс төрийн эрх чөлөө, шударга ёсны эрх чөлөө, үндэсний эрх чөлөө гэсэн үнэт зүйлсийг баримтлан эрхэм зорилгоо хэрэгжүүлэх үзэл баримтлалаар үйл ажиллагаагаа хэргэжүүлж байна.

Эрхэм зорилго нь: Хүн бүр хүсэл мөрөөдөлтэй, өрх бүр аз жаргалтай амьдрах хөгжлийн боломжийг дэмжсэн, иргэд нь эрх чөлөөтэй, эрх тэгш, хариуцлагатай, ардчилсан Монгол улсыг байгуулах. 2000 оны 12-р сарын 06-нд Монголын Ардчилсан Нам, Монголын Үндэсний Ардчилсан Нам, Монголын Социал Демократ Нам, Монголын Сэргэн Мандлын Нам, Монголын Шашинтны Ардчилсан Нам нэгдэж одоогийн “Ардчилсан нам” болсон. Тус нам 1992-1996 онд “Ардчилсан холбоо эвсэл” байгуулан ажиллаж, 1996-2000, 2012-2016 онд УИХ-д олонхи болон засгийн эрх барьж байсан. Нийт Улаанбаатар хотын 9 дүүргүүд болон 21 аймгуудад, Нийслэл, Ахмадын холбоо, Ардчилсан залуучууд, Ардчилсан эмэгтэйчүүд, Ардчилсан оюутаны холбоо бүхий нийт 35 салбартай. 2024 оны 01-р сарын 01-ны байдлаар Тайлант онд 42 УИХ-ын гишүүн, нийт 172,000 гишүүнтэй байна.

3.3 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна.

- Улс төрийн намын тухай хууль. 2024 оны 04-р сарын 19
- Хөдөлмөрийн тухай хууль 2024-01-12, 2024-06-05
- Нийгмийн даатгалын ерөнхий хууль 2024-06-05
- Татварын ерөнхий хууль 2024-01-12, 2024-05-16, 2024-06-05
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль 2024-01-12
- Статистикийн тухай 2024-05-16-ний өдөр тус тус өөрчлөлт орсон.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.4 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Ардчилсан Намын 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Ардчилсан Нам нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй байна.

3.5 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Ардчилсан Намын 2024 оны санхүүгийн тайланг Улс төрийн намын тухай хуулийн 36,37-р зүйл заалт, Сангийн сайд, Сонгуулийн Ерөнхий Хорооны хамтарсан 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 26-ны өдрийн А/243, 208-р тушаал, тогтоолоор баталсан “Улс төрийн намын санхүүгийн тайлангийн бүтэц, тайлагнах журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Анхан шатны баримтын бүрдэл бүрэн, Нягтлан бодох Бүртгэлийн алдааны залруулга хийгээгүй байна. Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа хэвийн сайн явагдсан байна. Аудитад бүрдүүлэх материалын жагсаалтыг илгээн, жагсаалтын дагуу аудитад шаардлагатай баримт материалуудыг бүрэн ирүүлсэн. Нийт төв, 21 аймаг, нийслэл, 9 дүүрэг, 3 холбоо, нийт 35 салбар зөвлөлийн санхүүгийн тайлангуудыг аудитад бүрэн хамруулан шалгасан.

Тайлант хугацаанд шалгагдагч байгууллагын зөвхөн төв салбар нь нягтлан болох бүртгэлийн Эрхэт програм дээр гүйлгээ оруулан санхүүгийн тайлан гаргадаг.Холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй, боловсруулан батлуулж мөрдөх шаардлагатай.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 340.8 сая төгрөгөөр буюу 25 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	644.28	102.57	-541.70
Авлага	12.99	25.09	12.10
Бараа материал	378.83	375.27	-3.57
Бусад эргэлтийн хөрөнгө	-	5.37	5.37
Үндсэн хөрөнгө	353.70	540.72	187.02
Нийт хөрөнгө	1,389.80	1,049.01	-340.78
Өр төлбөр	725.54	501.85	-223.69
Нийт эздийн өмч	664.25	547.17	-117.09
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,389.80	1,049.01	-340.78

Мөнгөн хөрөнгө данс: Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 102.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй. Үүний 14.1 сая төгрөг бэлэн мөнгө, 88.6 сая төгрөг харилцах дансанд байна. Төв салбар 4.3 сая төгрөг, Хөдөө орон нутгийн салбарууд 38.5 сая төгрөг,Нийслэл 26.1 сая төгрөг, 9 дүүргийн салбарууд 33.5 сая төгрөг, 3 холбоо 0.2 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл үлдсэнийг харилцах дансны үлдэгдлийн баталгаа болон бэлэн мөнгөний тооллогын баталгаагаар нотолсон байна. 2024 онд 212 иргэд 195.8 сая төгрөг, 2 хуулийн этгээд 12.0 сая төгрөг нийт 207.8 сая төгрөг хандивласан, намын гишүүний татвар 1,890.5 сая төгрөг, сонгуульт гишүүний татвар 3,565.0 сая төгрөг, төрийн санхүүжилт 443.0 сая төгрөг, түрээс болон бусад орлого 44.3 сая төгрөг, нийт 6,150.6 сая төгрөгийн санхүүжилт орсон ба үндсэн үйл ажиллагааны зардалд 6,114.7 сая төг, хөрөнгө оруулалтын зардалд 188.9 сая төгрөг зарцуулсан, УИХ, болон аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-д нэр дэвшигч гишүүд 14,066.1 сая төгрөгийг намын дансанд төвлөрүүлэн 14,066.1 сая төгрөг зарцуулсанийг санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээнд тусган толилуулсан байна. Өмнөх оны 389.0 сая төгрөгийн өр төлбөр төлсөн, 188.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан нь мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 541.7 сая төгрөгөөр буурах шалтгаан болжээ.

Авлага: Авлагын данс 12.1 сая төгрөгөөр нэмэгдсэн. Үүнд салбараас авах авлага 12.6 сая төгрөгөөр нэмэгдэж, 0.5 сая төгрөгийн өмнөх оны авлагыг барагдуулсан байна. Өмнөх оны 12.5 сая төгрөгийн барагдуулаагүй авлага байгаа нь эргэлтийн хөрөнгийн эргэцэд муу нөлөөтэй. Авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Бараа материал данс: Тайлант оны үлдэгдэлд хэвлэл сурталчилгааны материал 95.0 сая, хангамжийн материал 280.3 сая төгрөг нийт 375.3 сая төгрөгийн бараа материал бүртгэлтэй, 590.6 сая төгрөгийн бараа материалын орлого бүртгэж, 594.1 сая төгрөгийн бараа материал зарцуулсанаар 3.5 сая төгрөгөөр үлдэгдэл буурсаныг тооллого хийж, эд хариуцагчийн тооцоо бодсон акт үйлдэж баталгаажуулсан баримт ирүүлээгүй.

Бусад эргэлтийн хөрөнгө: Дансанд тайлант онд Ховд салбар 5.4 сая төгрөгийн хөрөнгө орлогоор бүртгэн тайланд тусгасан.

Үндсэн хөрөнгө данс: Тус дансанд 186.1 сая төгрөгийн компьютер дагалдах хэрэгсэл, 59.0 сая төгрөгийн тээврийн хэрэгсэл, 201.2 сая төгрөгийн тавилга, эд хогшил, 81.5 сая төгрөгийн бусад хөрөнгө, 11.2 сая төгрөгийн биет бус хөрөнгө, 14.6 сая төгрөгийн бусад эргэлтийн бус хөрөнгө, 12.9 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэл байгуулсан, нийт 540.7 сая төгрөгийн үлдэх өртөг бүхий үлдэгдлийг тодруулга тайланд тусгасан. Үндсэн хөрөнгийн тооллого хийсэн үлдэгдэл баталгаажуулсан баримт материал ирүүлээгүй.

Өр төлбөр данс: Өр төлбөр дансны үлдэгдэл 223.7 сая төгрөгөөр буурсан. Нийгмийн даатгалын байгууллагад 173.9 сая төгрөг, татварын байгууллагад 264.4 сая төгрөг, богино хугацаат өр, төлбөр 32.9 сая төгрөг байна. Бусад урт хугацаат өр төлбөр 636.5 сая төгрөгөөр буурч 30.6 сая төгрөг болсоныг тодруулга тайланд тусган нийт 501.8 сая төгрөгийн өр төлбөрөөс 438.3 сая төгрөгийн өр төлбөрийг тооцоо нийлсэн акт үйлдэн баталгаажуулсан байна.

3.6 Орлогын төлөвлөлт, гүйцэтгэлийн төсөв

Улс төрийн намын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу намын орлогын эх үүсвэрийг тодорхойлдог ба тайлант хугацаанд Ардчилсан Нам нь орлогын төлөвлөлт, гүйцэтгэлийн төсвийг нэгдсэн байдлаар гаргаж баталгаажуулаагүй тул энэ талаар хамаарах гүйлгээ, үр дүн байхгүй.

3.6.1 Орлогын төлөвлөлт

Энэ асуудлаар хамаарах гүйлгээ, үр дүн байхгүй.

3.6.2 Орлого, зардлын гүйцэтгэл

- Орлого үр дүнгийн тайлан.

Хүснэгт 2. Орлого үр дүнгийн нэгтгэсэн тайлан /дэлгэрэнгүй/

/сая төгрөгөөр/

Орлого, зардлын зүйл	Өмнөх үеийн дүн	Тайлант үеийн дүн	Өсөлт бууралт	
			сая төгрөгөөр	Хувиар
Намын гишүүний татвар	2,822.79	1,890.53	-932.26	-33%
Сонгуульт гишүүний татвар	-	3,565.00	3,565.00	
Мөнгөн хандив	444.97	207.76	-237.21	-53%
Төрийн санхүүжилт	137.50	442.96	305.46	222%
Төслийн санхүүжилт	368.00	-	-368.00	-
Намын өөрийн орлого	421.19	44.68	-376.51	-89%
Үйл ажиллагааны орлогын нийт дүн	4,194.45	6,150.93	1,956.48	47%
Ажиллагсдын зардал	738.05	1,262.50	524.45	71%
Ашиглалтын зардал	73.38	131.69	58.31	79%

Харилцаа холбооны зардал	96.90	64.61	-32.29	-33%
Түлш, шатахуун, тээврийн зардал	142.28	214.12	71.84	50%
Харуул хамгаалалтын зардал	42.82	85.81	42.99	100%
Засварын зардал	63.20	154.10	90.90	144%
Цахим орчин ашигласны зардал	-	22.47	22.47	-
Бичиг хэргийн зардал	8.52	118.15	109.63	1,287%
Элэгдэлийн зардал	23.28	12.93	-10.35	-44%
Татвар, төлбөр, хураамжийн зардал	7.85	18.61	10.76	137%
Томилолтын зардал	5.31	102.66	97.35	1,833%
Банкиндах гүйлгээний хураамж, шимтгэл	0.85	1.16	0.31	36%
Аудит мэргэжлийн үйлчилгээний зардал	8.56	45.96	37.40	437%
Мэргэжлийн үйлчилгээний зардал	387.00	493.27	106.27	27%
Түрээсийн зардал	168.35	562.53	394.18	234%
Хэвлэл, сурталчилгааны зардал	384.91	805.20	420.29	109%
Хангамжийн материалын зардал	189.43	528.86	339.43	179%
Сургалт семинар	79.87	136.93	57.06	71%
Даатгалын төлбөрийн зардал	-	0.12	0.12	
Торгууль, нөхөн төлөөсийн зардал	-	0.60	0.60	
Төрөл бүрийн хандив тусламж, хувийн хэрэглээ	3.00	21.86	18.86	629%
Арга хэмжээ	498.95	232.26	-266.69	-53%
Баяр ёслол	53.13	42.91	-10.22	-19%
Бусад	272.05	635.25	363.20	134%
Нийгмийн бүлгүүдийн улс төрийн оролцоог дэмжих сургалтын зардал	-	100.02	100.02	
Намын гишүүдийн болон иргэдийн боловсролыг дээшлүүлэх сургалтын зардал	-	85.57	85.57	
Судалгаа хийх, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх зардал	-	212.55	212.55	
Сонгуулийн зардал	-	94.37	94.37	
Бусад үйл ажиллагааны зардал	393.58	80.95	-312.63	-79%
Үйл ажиллагааны зардлын нийт дүн	3,641.27	6,268.01	2,626.75	72%
Үйл ажиллагааны үр дүн (1-2)	553.18	- 117.09	-670.27	-121%

Нийт 33 салбар, хороодын орлого үр дүн нэгтгэгдсэн. Намын гишүүдийн татвар 1,890.5 сая төгрөг, сонгуульт гишүүний татвар 3,565.0, түрээсийн болон бусад орлого 44.7 сая төгрөг, төрийн санхүүжилт 443.0 сая төгрөг, иргэд, хуулийн этгээдийн мөнгөн хандив 207.8 сая төгрөг нийт 6,150.9 сая төгрөгийн орлого хуримтлуулан бүртгэсэн. Сонгуульт гишүүний татварыг тайлант хугацаанд татан төвлөрүүлсэн нь өмнөх оны орлогоос 1,956.5 сая төгрөг буюу 47 хувиар өссөн үр дүн байна. 6,268.0 сая төгрөгийн үйл ажиллагааны зардал гарсан ба өмнөх оноос 2,626.8 сая төгрөгөөр буюу 72 хувиар зардал өссөн нь ажиллагсадын цалин, цалингаас тооцож төлөх нийгмийн даатгалийн шимтгэл, түрээсийн зардал өссөнтэй холбоотой байна.

- **Мөнгөн гүйлгээний тайлан**

Хүснэгт 3.Мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан /дэлгэрэнгүй/

/сая төгрөгөөр/

Орлого, зардлын зүйл	Өмнөх үеийн дүн	Тайлант үеийн дүн	Өсөлт бууралт сая төгрөгөөр	Өсөлт бууралт хувиар
Ажиллагсдын зардал	669.45	1,075.04	405.58	61%
НДШ-д	159.64	172.46	12.82	8%
Томилолтын зардал	75.31	102.66	27.34	36%
Ашиглалтын зардал	73.38	131.69	58.30	79%
Түрээсийн зардал	168.35	562.53	394.18	234%
Харуул хамгаалалтын зардал	42.82	85.81	42.99	100%
Харилцаа холбооны зардал	96.90	65.16	-31.74	-33%
Программ хангамжийн зардал	25.00	27.17	2.17	9%
Цахим орчин ашигласаны зардал	25.00	69.79	44.79	179%
Хангамжийн материалын зардал	483.42	539.05	55.63	12%
Бичиг хэргийн зардал	48.52	118.51	69.99	144%
Мэргэжлийн үйлчилгээний зардал	387.00	543.42	156.42	40%
Хэвлэл, сурталчилгааны зардал	391.50	246.10	-145.40	-37%
Түлш, шатахуун, тээврийн зардал	142.28	214.12	71.84	50%
Засварын зардал	93.20	183.61	90.41	97%
Намын гишүүдийн болон иргэдийн боловсролыг дээшлүүлэх сургалтын зардал	-	212.55	212.55	
Судалгаа хийх, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх зардал	-	369.83	369.83	
Сонгуулийн зардал	-	80.95	80.95	
Хурлын арга хэмжээний зардал	498.95	503.41	4.46	1%
Сурталчилгааны зардал	-	214.52	214.52	
Бэлэг дурсгалын зардал	-	25.67	25.67	
Баяр ёслолын зардал	93.13	147.11	53.98	58%
IDU арга хэжээний зардал	-	100.02	100.02	

Нийгмийн бүлгүүдийн улс төрийн оролцоог дэмжих сургалтын зардал	102.87	222.94	120.07	117%
Аудит мэргэжлийн үйлчилгээний зардал	8.56	45.96	37.40	437%
Татвар, төлбөр, хураамжийн зардал	7.85	18.61	10.75	137%
Даатгалын төлбөрийн зардал	-	0.12	0.12	
Торгууль, нөхөн төлөөсийн зардал	-	0.60	0.60	
Төрөл бүрийн хандив тусламж	13.00	24.16	11.16	86%
Банкиндах гүйлгээний хураамж, шимтгэл	0.85	1.16	0.31	37%
Бусад	513.69	10.03	-503.65	-98%
Үйл ажиллагааны зардлын нийт дүн	4,120.67	6,114.73	1,994.06	48%

